

# ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Булган сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/003/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар  
Аудитын менежер: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)  
Аудитор Б.Одхүү  
Утас: 70584207 Цахим хаяг: [odkhuu@audit.gov.mn](mailto:odkhuu@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-7
3. Аудитын илрүүлэлт .....	7
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	8

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг  
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
Утас: 7058-4203

АДДБ.03.25 № 420

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
М.ЭРХЭМБААТАР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Булган сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 91.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох 11.6 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

2126050240

### Бусад асуудлын хэсэг

Булган сумын 2025 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг сумын ИТХ-ын 2025 оны 12 сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 94.7 хувиар дүгнэсэн байна. Сумын засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг 77.1 хувиар дүгнүүлсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		677,818.18	<b>755,890.48</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	320,652.55	422,916.62
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	188,685.8	127,723.65
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	168,479.83	205,250.21
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,559,194.87	2,801,999.57
<b>6</b>	<b>1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12а, 12б, 12в</b>	<b>2,559,194.87</b>	<b>2,801,999.57</b>
7	1.2.2.02 Биет хөрөнгө		2,532,146.69	2,775,255.42
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	27,048.17	26,744.15
<b>9</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>3,237,013.05</b>	<b>3,557,890.05</b>
<b>10</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>15,106.7</b>	<b>112,484.93</b>
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		15,106.7	112,484.93
12	2.1.1.03 Өглөг		15,106.7	112,484.93
<b>13</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>3,221,906.35</b>	<b>3,445,405.12</b>
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,221,906.35	3,445,405.12
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		581,162.92	581,162.92
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		2,465,524.52	2,689,023.29
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		175,218.91	175,218.91
<b>18</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>3,237,013.05</b>	<b>3,557,890.05</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>2,794,109.6</b>	<b>2,541,167.09</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>390,344.3</b>	<b>453,533.25</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		315,672.56	316,580.19
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		352,613.62	356,580.19
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-36,941.06	-40,000
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		48,550.23	110,350.78
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		26,121.51	26,602.28
<b>8</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>1,099,483</b>	<b>2,087,633.84</b>
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	699,475.58
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,304,282.31	-
<b>11</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,419,042.81</b>	<b>1,448,624.18</b>
<b>12</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,419,042.81</b>	<b>1,380,298.88</b>
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,396,744.11	1,380,298.88
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		681,651.32	845,799.47
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		87,447.17	106,989.2
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		105,323.64	121,724.85
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		56,630.01	36,262.62
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		15,519.04	6,329.9

**ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ БУЛГАН СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		19,542	12,510
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,871.74	1,692.38
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		427,759.19	248,990.47
<b>22</b>	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>22,298.69</b>	<b>-</b>
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	68,325.3
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,375,066.8	1,092,542.92
<b>25</b>	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>562,891.16</b>	<b>869,044.15</b>
<b>26</b>	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>-562,891.16</b>	<b>-869,044.15</b>
<b>27</b>	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>812,175.63</b>	<b>223,498.77</b>

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,811,605.4</b>	<b>1,771,789.13</b>
<b>2</b>	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>390,344.3</b>	<b>453,533.25</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	315,672.56	316,580.19
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-36,941.06	-40,000
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	48,550.23	110,350.78
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	26,121.51	26,602.28
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,664.83	1,103.24
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	24,456.68	25,499.03
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,978.79	1,318,255.88
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	116,978.79	166,760.84
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0	699,475.58
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	452,019.46
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,304,282.31	0
<b>14</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,077,419.27</b>	<b>1,148,912.44</b>
<b>15</b>	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,077,419.27</b>	<b>1,148,912.44</b>
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,055,120.58	1,148,912.44
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,651.32	845,799.45
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,447.17	106,989.2
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,323.64	121,724.85
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	53,535.54	31,205.23
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	16,507.44	12,356.9
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	19,542	12,510
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,883.34	1,692.38
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	89,230.13	16,634.44
25	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,298.69	0
<b>26</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>734,186.12</b>	<b>622,876.69</b>
27	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	540,139.38	520,612.62
28	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	540,139.38	520,612.62
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	540,139.38	520,612.62
30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-540,139.38	-520,612.62
<b>31</b>	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>194,046.75</b>	<b>102,264.07</b>
32	1.2 Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	126,605.8	320,652.55
33	1 Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	320,652.55	422,916.62

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн / мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,409,730.72		2,409,730.72
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,409,730.72		2,409,730.72
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	812,175.63		812,175.63
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,221,906.35		3,221,906.35
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,221,906.35		3,221,906.35
6	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,221,906.35		3,221,906.35
8	1.7 Тайлант үеийн үр дүн	223,498.77		223,498.77
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,445,405.12		3,445,405.12

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / мянган төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,066,497.5</b>	<b>1,640,022.7</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,239,307.8</b>	<b>1,119,410.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,237,307.8</b>	<b>1,119,410.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	867,462.8	834,447.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,454.3	106,988.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,493.8	114,761.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,864.7	12,356.9
2107	Томилолт, зочны зардал	21,220.0	12,510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,920.2	1,648.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,706.6	11,034.4
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.0	-
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>708,189.7</b>	<b>520,612.6</b>
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	119,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	119,000.0	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,066,497.5</b>	<b>1,815,546.5</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,720,377.8</b>	<b>1,741,288.3</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,256,768.1	1,289,268.9
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	463,609.7	452,019.4
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	336,119.7	64,258.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.0	64,258.2
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	216,119.7	
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	10,000.0	10,000.0
122001	Хандив тусламж /дотоод/	10,000.0	10,000.0
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		320,652.5
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		422,916.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,007.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,007.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	9,007.4
<b>2101</b>	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	764.8
<b>2104</b>	Хангамж, бараа материалын зардал	2,642.5
<b>2109</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,400.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,007.4</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,007.4

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 60.4 сая төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 60.4 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 91.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 77.5 сая төгрөгөөр давсан тул *Хязгаарлалттай* дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 60.4 сая төгрөг буюу 4.8 хувиар тасарсан байна. Үүнд татварын орлого 36.5 сая төгрөгөөр, татварын бус орлого 23.9 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл хөрөнгийн орлого 8.3 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 12.7 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1.4 сая төгрөгөөр, газрын төлбөр 22.5 сая төгрөгөөр, торгуулийн орлого 24.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон ... орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

*Илрүүлэлт:* Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 90.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Хөрөнгө оруулалтын бус 124.6 сая төгрөгийн 19 арга хэмжээ төлөвлөж 104.2 сая төгрөгийн 13 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 20.4 сая төгрөгийн 6 арга хэмжээний санхүүжилтийг зогсоосонтой холбоотой бүрэн хэрэгжээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 83.6 хувийн гүйцэтгэлтэй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр 1,057.2 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан байна. ОНХС-ийн малын хөлийн татвараар хэрэгжүүлэхээр баталсан өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 15.0 сая төгрөгийн, ногоон тэжээл тариалах 6.0 сая төгрөгийн, малчдад зориулсан сургалт сурталчилгаа 10.0 сая төгрөгийн ажлууд татвар бүрдээгүйгээс хийгдээгүй байна. Тайлант оны төсөл, арга хэмжээний хэрэгжилт 97.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлэх, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган  
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 90.3 хувийн гүйцэтгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 60.4 сая төгрөг буюу 4.8 хувиар тасарсан байна.	1	60.4	-	-	1	60.4			-	-	-	-
Дүн	2	60.4	-	-	1	60.4	1		-	-	-	-